
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

ТОВЧ АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА.....
2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.....
3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР.....
4. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ.....
5. ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТ.....
6. ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН, БҮРТГЭЛ.....
7. ӨМЧ ХУВЬЧЛАЛ.....
8. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх нийслэлийн өмчийн талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх, нийслэлийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцаж, холбогдох шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж ажиллах үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Эрхэм зорилго

- Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөж, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилт

- Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн бодлого, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдлагаар хангах;
- Нийслэлийн өмчийн болон хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Захиргааны удирдлагын манлайлалыг хангах;
- Нийслэлийн төсвийн орлогын тодорхой хэсгийг бүрдүүлэх;
- Байгууллагын бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, үнэлгээ өгөх;

НЗД-ын 2018 оны 02 дугаар сарын 08 –ны өдрийн А/119 дүгээр захирамжаар НӨХГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг 4 хэлтэс 65 ажиллагсадтай байхаар баталсан. Тус захирамжийн хүрээнд НӨХГ-ын даргын 2018 оны Б/14 дүгээр тушаалаар бүтэц орон тоо, зохион байгуулалтын нэгжүүдийг баталсан. Байгууллагын хэмжээнд төрийн захиргааны албан хаагч 43, төрийн үйлчилгээний албан хаагч 22 нийт 65 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй тогтоол, шийдвэр журмууд:

НИТХ-ын 2014 оны 01 сарын 23-ны өдрийн 14/01 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг /2014 - 2020/

НИТХТ-ийн 2014 оны 04 сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоол

- Нийслэлийн өмчийн хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам
- Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам
- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам

НИТХТ-ийн 2014 оны 04 сарын 21-ний 55 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам
- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам
- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ
- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 66 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 67 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчийг хувьчлах журам
- Нийслэлийн өмч хувьчлах комиссын ажиллах журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоол

- Нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам

НИТХТ-ийн 2014 оны 05 сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоол

- Журамд нэмэлт өөрчлөлт оруулав.

Бага дунд боловсролын тухай хууль

Монгол Улсын Засгийн газрын "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгавар

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлж буй төлөвлөгөө

1. Байгууллагын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө

2. НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

3. Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

4. Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2018 оны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө

5. 2018 онд зохион байгуулагдах “Сургалтын төлөвлөгөө”, Мэдээллийн цагийн хуваарь

6. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөө

7. Монгол Улсын Засгийн газрын "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2017.10.26/

8. 2018 онд “Спорт хамтлаг”-ийн зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө

9. Авилгын эсрэг 2018 оны төлөвлөгөө

10. 2018 оны архивын ажлын төлөвлөгөө

Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэв:

НЗД-ын 2016 оны А/761 дүгээр захирамж	•НӨХГ-ын дүрэм
2016 оны Б/356 дугаар тушаал	•Байгууллагын хэлтсүүдийн чиг үүрэг
2018 оны А/269 дүгээр тушаал	•НӨХГ-ын стратеги төлөвлөгөө 2017-2020 он
2016 оны А/537 дугаар тушаал	•Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүний ажиллах журам
2016 оны А/411 дугаар тушаал	•Байгууллагын дотоод журам
2017 оны А/226 дугаар тушаал	•Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн,
2016 оны А/537 дугаар тушаал	•Ёс зүйн хорооны ажиллах журам
2017 оны А/50 дугаар тушаал	•Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
2018 онд батлагдсан	•Авилгын эсрэг төлөвлөгөө
2018 оны А/406 дугаар тушаал	•НӨХГ-ын албан хаагчдын ёс зүйн дүрэм
2017 оны А/252 дугаар захирамж	•Албан хэрэг хөтлөлтийн ажиллах журам

Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт /50%/:

Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг өгөөжийг нэмэгдүүлнэ. /50%/

Улаанбаатар хотын дүүрэг бүрд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих борлуулалтын нэгдсэн төвийг барьж “Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /50%/

"Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний загвар" төсөл хэрэгжүүлж, “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрүүл, баталгаат хоол хүнс хэрэглэх нөхцөл бүрдүүлнэ. /50%/

Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын төслийг боловсруулж хэрэгжүүлнэ. /50%/

Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

№	Тогтоол, шийдвэрүүд	Тоо	Хэрэгжилт хувь
1	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	1	100%
2	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	16	100%
3	Нийслэлийн Засаг даргын захирамж	32	90%
4	НЗД-ын Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл	2	100%
5	Засгийн газрын албан даалгавар	1	100%
6	Газрын даргын тушаал /А, Б/	364	100%
7	Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн	11 удаагийн хурал 28 үүрэг даалгавар	100%
8	Байгууллагын шуурхай хурал	25 удаагийн хурал 196 үүрэг даалгавар	168 - 100% 28 – 50%
9	Байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурал	5 удаа	100%

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол:

№	Төрөл	1
1	Хувьчлалын жагсаалт батлах тухай	1

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд өргөн барьж, шийдвэрлүүлсэн асуудлууд:

№	Нийт	16
1	Нийслэлийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөний талаар	14
2	Гүүрэн гарц барих төслийн ажлыг эрчимжүүлэх талаар	1
3	“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-г өөрчлөн байгуулах	1

Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой НЗД-ын 35 захирамж гарсан. Үүнд:

№	Нийт	32
1	Нийслэлийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөний талаар	20
2	Ажлын хэсэг байгуулах тухай	5
3	Төсөв, санхүүжилттэй холбоотой	4
4	Зорилт батлах тухай	1
5	Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай	1
6	Бусад	1

Газрын даргын тушаалууд:

№	Тушаал	364
1	Хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөнтэй холбоотой гарсан тушаал	310
2	Ажлын хэсэг байгуулах тухай	17
3	Спорт өдөрлөг зохион байгуулах тухай	1
4	Тооллого хийх тухай	2
5	Спортын наадам цасны баярт оролцох тухай	1

6	Удирдлагын зөвлөлийг шинэчлэн батлах тухай	1
7	Хариуцлагатай жижүүр, эргүүл томилон ажиллуулах тухай	1
8	Зардал гаргах тухай	5
9	"Б" хүний нөөцийн чиглэлээр	26

Ирсэн бичгийн шийдвэрлэлт:

	Хэлтэс	Нийт	Шийдвэрлэсэн	Судалж байгаа	Шийдвэрлэлтийн хувь
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	319	286	33	96,6%
2	Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс	1013	347	66	98,9%
3	Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтэс	452	421	31	97,5%
4	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс	65	65	-	97%
5	Нийт	1849	1719	130	97,5%

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааг өнгөрсөн оноос 39,8%-иар багасгалаа.



Дотоод ажлын талаар

Зохион байгуулсан арга хэмжээний талаар:



Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ: Цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагын харьяалалд бүртгэлтэй ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, гарын бэлэг гардуулах ажлыг 2018 оны 02 дугаар сарын 09, 13-ны өдөр зохион байгуулсан.



Томуугийн вакцинд хамрагдлаа: Нийслэлийн Өмчийн харилцааны газрын албан хаагчид 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Томуугийн вакцинд хамрагдлаа.



Бүх нийтийн их цэвэрлэгээ: "Их цэвэрлэгээний 90 минут" арга хэмжээгээр Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших "Хөрш заан" хотхоноос Зүүн тийш "UB town" хотхон хүртэл туул голын эрэг орчмын хогийг цэвэрлэсэн.



Бүх нийтийн мод тарих өдөр



Бүх нийтийн марафон уралдаан




Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр арга хэмжээ



Туршлага солилцох уулзалт:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн өмчийн газрын дарга, мэргэжилтнүүд 2018 оны 03 сарын 14-ний өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцан туршлага судлах уулзалт хийж, цаашид хамтран ажиллах тухай санал солилцлоо.



Бүтэн өнчин хүүхдүүдийн хөгжил санг дэмжин ажилласанд талархал илэрхийлэн тус газрын тэргүүн А.Батдорж 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр НӨХГ-ын дарга Ч.Однасанд Өргөмжлөл гардууллаа



Нийслэлийн төсөвт байгууллагуудын удирдлагатай байгуулсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2017 оны биелэлтийн дүнгээр өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээгээр хүлээсэн үүргээ "БҮРЭН ХАНГАЛТТАЙ" биелүүлж "НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ ӨМЧ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГА"-аар нийслэлийн 9 дүүрэг тус бүрээс 1 байгууллага шалгаруулаа.



НЗД-ын 2017 оны А/81 дүгээр захирамжийн дагуу гэрээгээр нийлүүлсэн 398.0 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг хүүхдийн зориулалттай автобусыг хүлээн авах ажлыг зохион байгуулан Налайх дүүргийн 59, Сонгинохайрхан дүүргийн 74, Хан-Уул дүүргийн 59 дүгээр сургуульд хүлээлгэн өгсөн.

Нийгмийн баталгааг хангах ажлын талаар:

Байгууллагаас тэтгэвэрт гарсан болон байгууллагын харьяалалд бүртгэлтэй 270 гаруй ахмад настанд сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардуулсан.

Төрийн албаны тухай хууль болон байгууллагын хөдөлмөрийн журмын дагуу ар гэрт нь гачигдал тохиолдсон 4 албан хаагчид тэтгэмж олгосон.

Ажлын цаг ашиглалтыг мөрдөн ажиллахад хяналт тавьж, эмнэлгийн чөлөөтэй 12 /листээр/, захиргааны чөлөөтэй 18, газрын даргын тушаалаар 1 албан хаагчийн чөлөө олгох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөн ажиллаж байна.

Ажилтан, албан хаагчдын 2018 оны ээлжийн амралтын хуваарийг албан хаагчдын санал, ажлын ачаалал, шаардлагад нийцүүлэн хийж газрын даргын 2018 оны Б/16 дугаар тушаалаар батлуулан ээлжийн амралтын мэдэгдлийг гарган ажиллаж байна.


Авилгын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах талаар:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст байгууллагын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийг жагсаалтыг хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах ТЗ-6-аас дээш ангиллын албан хаагчдаас 2017 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг, шинэчлэн томилогдсон 1 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч дуусган дүн мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлж, 1 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулсан.

"Нийслэлийн Өмчийн харилцааны газрын албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийн төслийг боловсруулан байгууллагын ёс зүйн хороогоор хэлэлцүүлэн, Авилгатай тэмцэх газраас санал зөвлөмж авсан.

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох стратегийн зорилтын хүрээнд:



Нийслэлийн өмчийн харилцааны талаарх мэдээ мэдээллийг түгээх, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын цахим хуудасны үйл ажиллагааны журам”-ыг байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаанд мөрдлөг болгон үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй ажлуудын талаарх мэдээллийг байршуулан ажиллаж байна.

- ✓ Байгууллагын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан цахим хуудасны мэдээллийг шинэчлэн засварласан. Үүнд:
 1. Утасны жагсаалт
 2. Хэлтсүүдийн ажил үүргийн хуваарь, бүтэц
 3. Албан хаагчдын цахим хаягийн мэдээлэл
- ✓ Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн нийт 20 мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

Төсвийн ил тод байдлын талаар:

Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажиллаж байна. Үүнд:

6.4.5. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ –

151 ш
11,956,183,767.06 төгрөг



6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ –

112 ш
12,354,699,594.20 төгрөг

6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

12 /тушаал/
13,575,500.00 төгрөг

Шүүхэд хянан хэлэлцэгдэж буй хэргүүд /Нийт 11/:



Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын талаар:

- “Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулах, сайжруулах аргачлал”-ын дагуу газрын даргын үр дүнгийн гэрээнд тусгасан үндсэн чиг үүргийн ажлуудын гүйцэтгэлийг хэлтсүүдийн холбогдох мэргэжилтнээс судалгааг авч нэгтгэн дүн шинжилгээ хийн мэдээг сар, улирал, жилээр гаргаж байна.
- Шилэн дансны тухай хуулийг мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийхэд Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажилласан байна.
- Байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд, тайлан, мэдээг цаг хугацаанд нь гүйцэтгэх, байгууллага, хэлтсийн хагас болон бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг загварын дагуу боловсруулах зэрэг дараах саналуудыг нэгтгэн гаргаж дотоод үйл ажиллагаандаа анхаарч ажиллаж байна.
- Үүнд:
 - Нийслэлийн засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 9.1-д заасны дагуу эрэмбэлэн тайлан гаргах;

- Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь захиргаа санхүүгийн хэлтэст гарын үсгээр баталгаажуулан хүргэх, тайланд хэрэгжилтийн явцыг оруулах;
- дээрх журмын 8.6.7-д заасны дагуу байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжээр тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээ, тайланд шинжилгээ хийлгэж, баталгаажуулах ;
- Imonitoring-д 90%-аас доош үнэлгээтэй оруулсан тогтоол, захирамжийн хэрэгжилтийг дахин шалгах;
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын даргын үр дүнгийн гэрээний зорилтод тусгагдсан дутуу биелэлттэй, хэрэгжүүлж эхлээгүй ажлыг эрчимжүүлэх, цаг хугацаанд нь гүйцэтгэн, тайланд тусгах;
- Байгууллагын газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг бүр ажлын тайланг өгч хэвших, хэлтсийн тайланд оруулах;
- Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 4-т заасны дагуу баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих;
- Хэлтсүүд мэдээ, тайлан гаргахдаа зөв бичгийн дүрмийн, эдийн засгийн үзүүлэлтийн болон техникийн алдаа гаргахгүй зэрэг байна.

ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ

Байгууллагын 2018 оны санхүүжилт болох орон нутгийн төсвөөс **1,061,915.5 сая** төгрөг, жилийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх **449,869.0 сая** төгрөг, нийт **1,511,780.5 сая** төгрөгийн төсөв батлагдсан.

Эдийн засгийн үзүүлэлт	Жилээр	Тайлант үе	Гүйцэтгэл
Төсвөөс урсгал санхүүжилт	1,061,911,500.0	551,813,600.0	551,813,600.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	449,869,000.0	255,456,400.0	104,318,462.8
Үндсэн ба нэмэгдэл цалин	738,452,200.0	369,226,200.0	261,121,937.0
Ажилчдын тоо	65	65	65
Нэг хүнд ногдох дундаж цалин	11,360,803.0	5,680,403.0	4,017,260.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	29,500,000.0	12,980,400.0	4,770,000.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,544,700.0	14,272,200.0	13,178,044.6
Хангамж бараа материалын зардал	53,700,000.0	26,250,000.0	23,819,380.8
Бараа үйлчилгээний зардал	17,220,000.0	9,360,200.0	5,168,888.0

- Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, зардлын хуваарийг сар, улирлаар гарган Санхүү төрийн сангийн хэлтсээр батлуулан мөрдөж, гүйцэтгэлд хяналт тавин, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 01-ний дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлэн, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын төлөвлөгөөг сар, улирлаар хуваарь гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулсан.
- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2017 оны жилийн эцсийн тайлан балансыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хуулийн хугацаанд гаргаж “Нийслэл дэх Төрийн Аудит”-ын газраар хянан баталгаажуулж, Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.
- Хөрөнгийн хөдөлгөөний тайланг холбогдох мэдээллийн санд оруулан Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газрын батлагдсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж, холбогдох хэлтэст хүргүүлсэн.


- 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмж, актын биелэлтийг хангах төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулж, биелэлтийг Нийслэл дэх Төрийн Аудитын газарт хүргүүлсэн.
- Хөрөнгө оруулалтын 2017 оны 7 аж ахуйн нэгжийн 261,700,000 төгрөгийн барьцааг чөлөөлж, 4 аж ахуйн нэгжийн 38 100 000 төгрөгийн барьцааг шинээр бүртгэсэн.
- Нэмэлт санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын 2018.01.19-ний өдрийн А/44 дүгээр захирамжаар “Нийслэлийн Орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал 352,446,600 /гурван зуун тавин хоёр сая дөрвөн зуун дөчин зургаан мянга зургаан зуун/ төгрөг, “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ын үйл ажиллагааны зардал 150,000,000 /нэг зуун тавин сая/ төгрөг, “Авто худалдааны цогцолбор” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал 284,329,800 /хоёр зуун наян дөрвөн сая гурван зуун хорин есөн мянга найман зуун/ төгрөгийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгосон.
- Нийслэлийн Засаг даргын А/453 дугаар захирамжаар Өмч хувьчлалын үйл ажиллагааны зардалд 87,000,000 /наян долоон сая/ төгрөг батлагдсанаас, 38,822,820 /гучин найман сая найман зуун хорин хоёр мянга найман зуун хорин/ төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан.
- Хөрөнгө оруулалтын 4 удаагийн эрх шилжүүлсэн ажлаар 761,000,000 /долоон зуун жаран нэгэн сая/ төгрөгийн гэрээг хянаж санхүүжилтийг олгосон, мөн хүү торгуулийн 3,800,000 /гурван сая найман зуун мянган/ төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн.
- Түрээслэгч болон харилцагч нартай тооцоо нийлэн Өр, авлагын тооцоо хийж 22 байгууллагын 60 400 000 /жаран сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг барагдуулж төсөвт төвлөрүүлсэн.
- Санхүүгийн тооцоолох ХХК-тай хамтран төсөвт байгууллагын программын шинэчлэлтийг цаг тухай бүрт хийлгэсэн.
- Санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 171/111 дүгээр тушаалаар батлагдсан хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх, бүртгэлээс хасах баримтыг бүрэн хөтөлж хэвшсэн.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/268 дугаар тушаалын дагуу эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн программ бүртгэлтэй тулган, албан хаагчдын хөрөнгийг бүрэн хамруулан тоолж картыг шинэчлэн бүртгэлээ.
- Тооллогоор илэрсэн актлах шаардлагатай эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж, Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын хуралд оруулж шийдвэрлүүлэн, актлан, данс бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Төсөвт төвлөрүүлэх орлого төрөл	Эхний хагас жилийн байлдаар			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Түрээсийн орлого	800,000.0	800,613.3	100%	/613.3/
2	Өмч хувьчлал	600,000.0	8,589,815.3	-	/7,989,815.3 /
3	Ногдол ашиг	150,000.0	40,000.0	27%	110,000.0
4	Актлагдсан хөрөнгө борлуулсны болон автомашины дуудлага худалдааны орлого	42,000.0	68,635.3	163%	/26,635.3/
Дүн		1, 592,000.0	9,499,063.9		/7,907,063.9/

2016 оны гүйцэтгэлийг 2017 оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй харьцуулвал /мян.төг/



Түрээсийн гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэлтийн хэрэгжилт:

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр гарган Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулж хагас жилийн байдлаар 800,000,000.0 төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс 800,613,300.0 төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэн төлөвлөгөөг 100% биелүүлэн, дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- ✓ Нийслэлийн Соёлын Төв Өргөөний түрээслэгч 9 байгууллагын 422,2 сая төгрөгийн үнийн дүн бүхий түрээсийн гэрээг хянан удирдлагаар батлуулсан.
- ✓ Дам болон шууд түрээсийн 1,022,403,213 төгрөгийн үнийн дүн бүхий 120 гэрээг хянан, бүртгэж коджуулсан.

НИТХ-ийн 2010 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн нэг метр квадрат талбайн түрээсийн төлбөрийн доод үнэ”-ийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг шинэчлэх саналын судалгааг гарган боловсруулж, НЗДТГ-ын холбогдох хэлтсүүдээс санал авч, НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барьж батлуулсан. Хууль зүйн яамнаас НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ыг шинэчлэх шаардлагатай гэж үзсэн.

Түрээсийн гэрээ, төлбөртэй холбоотой судалгаануудыг гарган ажиллаж байна. Үүнд:

- ✓ “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн нэг метр квадрат талбайн түрээсийн төлбөрийн доод үнэ”-ийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг шинэчлэх саналын судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ “Буянт-Ухаа” орон сууцны хорооллоос нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчидтай байгуулсан гурвалсан гэрээний байрны төлбөрийн 30 хувийн бүрдүүлэлтийн 3 жилийн гүйлгээг шивж, тулган, тооцоо нийлж, төлбөрийн үлдэгдэл барагдуулах, судалгаа тайлан мэдээ, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболдод танилцууллаа. Урт цагаан үйлчилгээний төвийн гэрээний түрээсийн төлбөр, ашиглалтын зардалтай холбоотой судалгаа
- ✓ КРІ-ын түрээстэй холбоотой судалгаа
- ✓ Түрээслэгч нарын салбарын судалгаа
- ✓ “Буянт-Ухаа” орон сууцны хорооллын 15 байгууллагын 30 албан хаагчийн орон сууцны төлбөр бүрдүүлэлтийн судалгаа
- ✓ Өмч эзэмшүүлэх гэрээ дүгнэх ажлын хэсэгт түрээсийн өр төлбөрийн судалгаа

Өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөний талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/24 дүгээр тогтоолоор 2018 онд хувьчлагдах жагсаалтыг батлуулан, нийслэлийн төсөвт 6.0 /зургаан тэрбум/ төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсанаас нээлттэй дуудлагын худалдаагаар 1 аж ахуйн нэгж, 1 барилгыг хувьчилж **8,744,000,000** /найман тэрбум долоон зуун дөчин дөрвөн сая/ төгрөгөөр худалдан, нийслэлийн төсөвт төвлөрүүлж, хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 146 хувьтай байна.

Акталж данснаас хассан хөрөнгийн орлогын талаар:

Газрын даргын 2018 оны нийт 84 тушаалаар **3,079,732,491,.5** төгрөгийн бүртгэлийн үнийн дүн бүхий актлагдсан хөрөнгийг татан төвлөрүүлсэн. Газрын даргын 2017 оны А/202-р тушаалаар байгуулагдсан Үнэлгээний комисс дахин үнэлгээ хийж техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон, акталж данс бүртгэлээс хасагдсан хөрөнгийг үнэлж, худалдан борлуулж устгалын акт үйлдэн, нийт **68,635,300** төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТ**Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулах ажлын хүрээнд:**

Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/45 дугаар захирамжаар “Ажлын хэсэг” байгуулагдан, 5 удаагийн хуралдаанаар орон нутгийн өмчит 32 үйлдвэрийн газруудын 2018 эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтот түвшний төслийг хэлэлцсэн. Хуралдааны санал, дүгнэлтийг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн НЗД-ын Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж НЗД-ын А/259 дүгээр захирамжаар баталсан.

32 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

20 аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар


12 төсөвт үйлдвэрийн газар

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын орлого, зардал, ашиг алдагдал

/сая. төгрөг/


№	Үзүүлэлт	2016 он		2017 он		2018 он
		гүйцэтгэл	зорилт	гүйцэтгэл	зорилт	зорилт
1	Нийт орлого	208,024,177.0	241,751,372.1	240,610,651.9		244,883,437.6
2	Нийт зардал	254,679,678.	271,212,695.	258,111,438.		273,959,909.4

		4	5	8	
3	Нийт ашиг/алдагдал	-	-	-	-
	Борлуулалтын 1 төг. ногдох зардал	46,655,501.4	29,461,323.4	17,500,786.9	29,076,471.80
		1.22	1.12	1.07	1.12



Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/356 дугаар захирамжаар орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Контрактын биелэлтийг дүгнэх ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг батлагдсан хуваарийн дагуу 7 удаагийн хурал зохион байгуулан орон нутгийн өмчит 32 үйлдвэрийн газрын 2017 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлтийг хэлэлцэн дүгнэж үнэлгээ болон танилцуулгыг НЗД-ын

Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.



Орон нутгийн өмчит 3 үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалт, дүрэмд өөрчлөлт оруулах талаар хийгдсэн ажил:

№	НИТХТ-ийн тогтоол	Байгууллага	Байгууллагад оруулсан өөрчлөлт
1	2018 оны 51 дүгээр тогтоол	“Нийслэлийн орон сууцны корпораци” ОНӨААТҮГ	Хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан
2	2018 оны 28 дугаар тогтоол	“Авто худалдааны цогцолбор” ОНӨААТҮГ	Үйл ажиллагааг өргөтгөн “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК болгон өөрчлөн байгуулж, дүрмийг батлуулсан.
3	2018 оны 73 дугаар тогтоол	“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ	НЗД-ын А/239 дүгээр захирамжаар тус газрыг 2 үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах санал боловсруулан НИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн тогтоолыг гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

НӨҮГ болон Өмчийн оролцоотой компанийн ТУЗ, УЗ-д нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх:

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулан дараах байгууллагуудын хуралд холбогдох мэргэжилтнүүд оролцож саналаа тусгуулж ажиллаа. Үүнд:

- Ус сувгийн удирдах газар - 1
- Улаанбаатар зам засвар арчлалтын газар - 1
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар - 1
- Хот тохижилтын газар - 1
- Зураг төслийн хүрээлэн - 1
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар - 1
- Гэрлэх ёслолын ордон - 1

Мөн “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралд хэлэлцэх асуудлыг боловсруулан, удирдамжийг батлуулан итгэмжлэгчийг томилон оролцуулсан.

Нийслэлийн өмчийн оролцоотой болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 4 компани, 3 үйлдвэрийн газрын ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх, томилох асуудлыг НИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж 102 дугаар тогтоолоор баталсан.

Төсөвт газруудтай байгуулсан Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулах дүгнэх:

Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 2017 онд:

660 байгууллага гэрээ дүгнүүлсэн.

Төр захиргааны байгууллага
34

Эрүүл мэндийн байгууллага
24

Төсөвт байгууллага
123

Цэцэрлэг
227


Сургууль
119

Өрхийн эмнэлэг
133

Гэрээг дүгнэх ажлыг 3 багц бүхий 11 үзүүлэлтээр, тодруулбал түрээсийн гэрээтэй байгууллагуудыг 11 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор, түрээсгүй байгууллагуудыг 9 үзүүлэлтээр 85 хүртэлх оноогоор дүгнэж, нийт авсан оноог хувиран дүнг гарган, дүгнэлтийг холбогдох зөвлөмжийн хамт тухайн байгууллагуудын удирдлагуудад танилцуулж баталгаажуулсан:

Үнэлгээ	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	Төр захиргааны байгууллагууд	Нийт
Бүрэн хангалттай	17	14	80	72	28	61	77	67	63	27	506
Хангалттай	6	1	6	33	3	43	6	9	8	2	117
Ажил сайжруулах	2			6		3	4	3		1	19
Хангалтгүй			1			1	1			0	3
Дүгнэгдээгүй	2			4		1		1	3	4	15
Нийт	27	15	87	115	31	109	88	80	74	34	660

2016 болон 2017 оны байгууллагуудын гэрээ дүгнүүлсэн байдлаар нь харьцуулбал:




Захиалагчийн хяналт тавьж ажилласан ажлын талаар:



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН

Нийслэлийн өмчид бүртгэлтэй эд хөрөнгийн талаарх мэдээлэл:

Төрийн өмчийн бүртгэлийн шинэчилсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-д нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой **758** байгууллагын 2017 оны тайланг 100 хувь хүлээн авч нэгтгэсэн. Нийслэлийн өмч 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансаар нийт **2,087,887.1 сая төгрөг**ийн хөрөнгө байгаагаас **эргэлтийн бус хөрөнгө 1,581,182.5 сая төгрөг**, **эргэлтийн хөрөнгө 506,704.5 сая төгрөг** байна. Үүнд:



Нийт 523 байгууллага барилга байгууламжтай	Балансын үнэ: 1,154,521,797,032.48 төгрөг	Барилга: 988,284,122,980.06 төгрөг
		Байгууламж: 166,237,674,052.42 төгрөг

Нийслэлийн өмчид бүртгэлтэй нийт барилгын задаргаа:

№	Барилгын төрөл	Тоо	Балансын үнэ
1	Цэцэрлэгийн барилга	305	161,682,884,228.23
2	Сургуулийн барилга	300	344,941,719,435.74
3	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилга	53	3,993,488,898.90
4	ОНӨААТҮГ-н барилга	1583	157,154,179,224.79
5	Эрүүл мэндийн байгууллагуудын барилга	140	114,561,251,747.85
6	Цагдаагийн байгууллагын барилга	81	19,720,115,049.92
7	Онцгой байдлын газруудын барилга	37	8,616,647,229.00
8	Дүүргийн төр захиргааны байгууллагуудын барилга	353	117,049,635,249.06

9	Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын барлга	142	60,564,201,916.57
Дүн		2994	988,284,122,980.06

Барилгыг насжилтаар нь ангилбал:

№	Ашиглалтанд орсон он	Ашигласан жил	Барилгын тоо
1	1960 оноос өмнөх	58-с дээш	105
2	1961-1970	48-58	174
3	1971-1980	38-48	370
4	1981-1990	28-38	457
5	1991-2000	18-28	253
6	2001-2010	8-18	779
6	2011 оноос хойшхи	7 ба түүнээс бага	856
БҮГД ДҮН			2994

Нийт 305 байгууллагад 158,953,150,373.97 төгрөгийн 2044 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг. Үүнд:

№	Автомашинны төрөл	Тоо
1	Жип	77
2	Суудлын автомашин	726
3	Автобус микроавтобус	349
4	Трактор механизм	42
5	Ачааны машин	405
6	Мотоцикл	143
7	Тусгай зориулалтын машин	302
		2044

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд өргөн барьж шийдвэрлүүлсэн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой асуудлууд:

№	Төрөл	Нийт 14
1	Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэх тухай	5
2	Нийслэлийн өмчийн бүртгэлээс барилга байгууламж хасах тухай	7
3	Барилга байгууламж балансаас балансад шилжүүлэх тухай	2

Нийслэлийн Засаг даргын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой гаргасан захирамжууд:

№	Төрөл	Нийт 20
---	-------	---------

1	Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэх тухай	7
2	Тээврийн хэрэгсэл нийслэлийн өмчид бүртгэх тухай	6
3	Хөрөнгө актлах тухай	7

Газрын даргын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой гаргасан тушаалууд:

№	Төрөл	Нийт 310
1	Эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай	145
2	Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай	118
3	Эргэлтийн бус хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай	47

Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар:

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон эд хөрөнгийг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгах, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн дансны залруулга хийх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлэх, нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, тайлант онд хийгдсэн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг өмчийн мэдээллийн санд бүрэн гүйцэд оруулсан эсэхийг шалгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын болон дотоодын хандив, буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгөөр шинээр бий болсон **нийт 37,672,436,603 төгрөгийн** хөрөнгийг бүртгэлд тусгасан байна. Үүнд:



Барилга байгууламж
• 26 нэрийн
• **22,5 тэрбум.төг**




Автозам
• 1ш
• **598,8 сая.төг**



Тээврийн хэрэгсэл
• 11ш
• **1,79 тэрбум.төг**



Нийтийн эзэмшлийн хөрөнгө, их засварын ажил
• **3,12 тэрбум.төг**



ЭБХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө
• **1,87 тэрбум.төг**



Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал
• **7,74 тэрбум.төг**

1. Барилга байгууламж

№	Тогтоол захирамж	Барилга байгууламж	Бүртгэлийн үнэ /төгрөг/
1	НИТХТ-ийн 2017 оны 170 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/47 дугаар захирамж	10 барилга байгууламж	7,999,187,984 төгрөг
2	НИТХТ-ийн 2017 оны 171 дүгээр тогтоол, НЗД-ын 2018 оны А/93 дугаар захирамж	4 барилга байгууламж	7,395,783,693 төгрөг
3	НИТХТ-ын 2018 оны 02 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/95 дугаар захирамж	Түргэн тусламжийн төвийн барилга байгууламж	2,681,781,116 төгрөг
4	НИТХТ-ын 2018 оны 39 дүгээр тогтоол, НЗД-ын 2018 оны А/385 дугаар захирамж	2 барилга байгууламж	2,314,056,287 төгрөг
5	НЗД-ын 2018 оны А/393 дугаар захирамж	“Ус дулаан дамжуулах төв”-ийн барилга	388,648,043 төгрөг
6	НЗД-ын 2018 оны А/479 дүгээр захирамж	Ус түгээх байр /6 ширхэг/	256,914,631 төгрөг
7	НИТХТ-ын 2018 оны 83 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/385 дугаар захирамж	2 барилга байгууламж	1,499,531,203 төгрөг
Нийт дүн: 22,535,902,957 төгрөг			

2. Автозам

Баянгол дүүргийн 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар барьж, ашиглалтад оруулан, нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлж байгаа **598,807,720** төгрөгийн үнэ бүхий 1.0 км автозамыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 06 дугаар сарын 05-ны өдрийн А/512 дугаар захирамжаар нийслэлийн өмчид бүртгэх шийдвэрийг гаргуулан тус ажлыг нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулсан.

3. Тээврийн хэрэгсэл

НЗД-ын 2018 оны А/26 дугаар захирамж		
1	Хот тохижилтын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл 2 ширхэг	887,900,000
НЗД-ын 2018 оны А/55 дугаар захирамж		
1	HOWO маркийн өөрөө буулгагч автомашин, DONGFENG маркийн крантай автомашин, B75W8, FUJIAN маркийн дугуйт экскаватор /3 ш/	363,000,000
НЗД-ын 2018 оны А/81 дүгээр захирамж		
1	Автобус 3 ширхэг	398,000,000
НЗД-ын 2018 оны А/94 дүгээр захирамж		
1	ЧД-ийн 5 өрхийн эрүүл мэндийн төвд тээврийн хэрэгсэл	69,930,000
НЗД-ын 2018 оны А/248 дүгээр захирамж		
1	“Хюндэй Старекс” маркийн микроавтобус	20,000,000
НӨХГ-ын 2018 оны А/28 дугаар тушаал		
1	Бонго маркийн 3 ширхэг тээврийн хэрэгсэл	52,400,000
Нийт дүн: 1,790,900,000 төгрөг		

4. Засварын ажил

Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийтийн эзэмшлийн хөрөнгө, их засварын **3,129,845,926** төгрөг бүхий 8 ажлыг НӨХГ-ын даргын тушаалаар нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулсан.

5. ЭБХХХК-ын хурлын шийдвэрээр бүртгэсэн эд хөрөнгө – **1,870.2 сая төгрөг**

Төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн байгууллагуудын хүсэлтийг комиссын хурлаар хэлэлцүүлж, давхардсан тоогоор **101** байгууллагын **1,870.2 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх Газрын даргын тушаал батлуулсан. Үүнд:

✓ Багануур дүүргийн 4 байгууллагын	23.9 сая төгрөг
✓ Налайх дүүргийн 1 байгууллагын	2.9 сая төгрөг
✓ Баянгол дүүргийн 20 байгууллагын	265.1 сая төгрөг
✓ Баянзүрх дүүргийн 29 байгууллагын	615.9 сая төгрөг
✓ Сонгинохайрхан дүүргийн 12 байгууллагын	81.1 сая төгрөг
✓ Сүхбаатар дүүргийн 16 байгууллагын	80.6 сая төгрөг
✓ Хан-Уул дүүргийн 8 байгууллагын	327.3 сая төгрөг
✓ Чингэлтэй дүүргийн 11 байгууллагын	473.4 сая төгрөг

6. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал – **7,746.78 сая төгрөг**

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Автозамын хөгжлийн газар зэрэг захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр бий болсон шугам сүлжээ, автозам, тохижилт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт **7,746.78 сая** төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон **78** албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн.

“Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон **3,516.0 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэлд авсан шийдвэрийг **100** байгууллага ирүүлснийг хүлээн авч судалгаанд хамруулав.

ЭБХХХК-ын шийдвэрээр 8 байгууллагын 32.0 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд, 4 байгууллагын 41,0 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд, 6 байгууллагын 255.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэх буюу дансны залруулга хийх 18 тушаал гарган хүргүүлсэн.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орж буй барилга байгууламжийг ашиглалтад оруулах, их засварын ажил хүлээн авах нийт **6,081.8 сая** төгрөгийн төсөвт өртөг бүхий **14** комиссын бүрэлдэхүүнд орж дүүрэг хариуцсан мэргэжилтнүүд санал, дүгнэлт өгч ажилласан.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, 2018 онд санхүүжих 496 төсөл арга хэмжээний судалгааг жагсаалтаар гаргалаа. Үүнд:

✓ НТХО-аар хийгдэх	– 70.5 тэрбум төгрөгийн 191 ажил
✓ Замын сангийн	– 24.0 тэрбум төгрөгийн 66 ажил
✓ НОНХС-ийн	– 9.5 тэрбум төгрөгийн 164 ажил
✓ УТХО-аар	– 53.3 тэрбум төгрөгийн 75 ажил

Данснаас хассан хөрөнгийн талаар:

2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт **13,650,027,458.6** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 38 нэрийн барилга байгууламжийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг НИТХТ-ийн тогтоол, НЗД-ын захирамжаар шийдвэрлүүлээд байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад нийслэлд “Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”, “Хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөр”-д цэцэрлэг, сургуулийн барилга баригдахаар тусгагдсан байна.

Үүнд:

НИТХТ-ийн 2018 оны 15 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/247 дугаар захирамж		
1	СХД-ийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн эрүүлжүүлэхийн байр, гаражийн барилга	144,834,24.0
НИТХТ-ын 2018 оны 42 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/378 дугаар захирамж		
1	БЗД-ийн 21-р сургуулийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	1,971,507,775.6
2	БЗД-ийн 50-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	393,868,705.6
3	БЗД-ийн 59-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	426,531,625.0
4	СХД-ийн 55-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	388,965,530.0
5	СХД-ийн 5-р хорооны хуучин барилга	127,820,000.0
6	ХУД-ийн 28-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	620,709,381.0
7	ХУД-ийн Хүүхдийн клиник 4 дүгээр сувиллын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	884,939,571.0
8	ЧД-ийн 4-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	397,425,208.0
9	ЧД-ийн 33-р цэцэрлэгийн барилга байгууламж	592,926,906.0
10	ЧД-ийн 43-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	93,866,294.0
Нийт дүн: 5,898,560,996.2 төгрөг		
НИТХТ-ын 2018 оны 64 дүгээр тогтоол, НЗД-н 2018 оны А/478 дугаар захирамж		
1	БЗД, БГД, СБД, СХД, ХУД, ЧД-ийн нутаг дэвсгэрт байрлах Ус түгээх байр /12 ширхэг/, резерваурын байр /1 ширхэг/	169,430,688.66
НИТХТ-ын 2018 оны 65 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/511 дүгээр захирамж		
1	СБД-ийн 24-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	480,093,579.7
2	СБД-ийн 1 дүгээр сургуулийн спорт заал бүхий өргөтгөлийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	2,667,735,362.9
Нийт дүн: 3,147,828,942.6		
НИТХТ-ын 2018 оны 66 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/510 дугаар захирамж		
1	БГД-ийн 34-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	324,664,800.0
	БГД-ийн 34-р цэцэрлэгийн агуулахын барилга	735,000.0
2	БГД-ийн 13-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	395,295,000.0
3	БГД-ийн 19-р сургуулийн Хичээлийн 1 дүгээр байрны барилга байгууламж	857,556,000.0
	БГД-ийн 19 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга байгууламж	712,306,000.0
	БГД-ийн 19 дүгээр сургуулийн агуулах	2,205,000.0
	БГД-ийн 19 дүгээр сургуулийн гараж	3,742,600.0
4	БГД-ийн 30-р цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн	406,187,450.0

эзэмшлийн эд хөрөнгө		
Нийт дүн: 2,702,691,850.0 төгрөг		
НИТХТ-ын 2018 оны 90 дүгээр тогтоол		
1	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороонд байрлах конторын барилга	29,826,770.0
2	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороонд байрлах зоорийн барилга	7,270,000.0
Нийт дүн: 37,096,770 мянган төгрөг		

2. Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар цэцэрлэг, сургуулийн хуучин барилгыг буулгаж шинээр барих болсон тул Баянзүрх, Хан-Уул дүүргийн 2 барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах шийдвэрийг гаргуулсан.

НИТХТ-ын 2018 оны 41 дүгээр тогтоол, НЗД-ын 2018 оны А/377 дугаар захирамж


№	Барилга байгууламжийн нэр	Бүртгэлийн үнэ
1	БЗД-ийн 3 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	360,897,520.0
2	ХУД-ийн 75 дугаар сургуулийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	1,188,708,715.5
Нийт дүн: 1 549 606 235,5		

Тээврийн хэрэгсэл данснаас хасах ажлын талаар:

Нийслэлийн өмчит 21 байгууллагын 36 тээврийн хэрэгслийг газар дээр нь үзэж танилцан тэмдэглэл хөтлөн, чанар байдалд дүгнэлт хийж, 27 тээврийн хэрэгслийг данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлэхээр үнэлгээ хийлгэж байна.

“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлыг зохион байгуулах:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын 14 удаагийн хурлаар нийт 283 байгууллагын 4505 нэр төрлийн эд хөрөнгийн худалдан авах, шинээр бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, данснаас хасах зэрэг асуудлуудыг холбогдох хууль журамд нийцүүлэн нийт **12,383,268,196 төгрөгийн** хөрөнгийг хэлэлцүүлэн зөвшөөрөл олгохоор шийдвэрлэв. Үүнд:



ӨМЧ ХУВЬЧЛАЛ

Өмч хувьчлалын ажлын талаар:

Өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилтын хүрээнд Нийслэлийн өмчөөс хувьчлах хуулийн этгээд, барилга байгууламжийн жагсаалтыг нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтыг ханган биелүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, нийслэлийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан боловсруулж Нийслэлийн өмчөөс 2018 онд хувьчлагдах 1 аж ахуйн нэгж, 7 барилга байгууламжийн жагсаалт, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх өмч хувьчлалын орлогыг 6,0 тэрбум төгрөгөөр тогтоох тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж 2017 оны НИТХ-ын 02/24 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчөөс 2018 онд хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг батлуулсан.


Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 1 удаагийн хурлаар 8 асуудал хэлэлцүүлэн, 8 тогтоол гаргасан. Үүнд:

- Шинээр хувьчлах тухай – 4
- Өмчлөгчийн эрх олгох тухай – 1
- Хувьчлалын тайлан батлах тухай – 3

Тайлант хугацаанд өмч хувьчлалын нээлттэй дуудлага худалдааг нийт 3 удаа зохион байгуулж 1 аж ахуйн нэгж, 1 барилга байгууламжийг худалдан борлуулж нийслэлийн төсөвт 8,744,000,000 /найман тэрбум долоон зуун дөчин дөрвөн сая/ төгрөгийг төвлөрүүлсэн.



2018.01.04-ний өдрийн дуудлагын худалдаа:
Байршил: СБД-ийн 8 дугаар хороо
Аж ахуйн нэгж: "Усан спорт сургалтын төв" НӨҮГ
Худалдан борлуулсан үнэ: 8,702,000,000 төгрөг



2018.05.10-ны өдрийн дуудлагын худалдаа:
Байршил: ХУД-ийн 6 дугаар хороо
Объект: Цагдаагийн түр саатуулах байр
Худалдан борлуулсан үнэ: 42,000,000 төгрөг

Тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны талаар:

Тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааг 4 удаа зохион байгуулсан.

29 байгууллагын 32 тээврийн хэрэгслийг худалдан борлуулсан.

Нийт 44,4 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авалтын төлөвлөгөөг ил тод болгон, худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хяналтыг сайжруулах, удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулан төсвийн зардлыг хэмнэх
2. Дүүргүүдийн ОНӨҮГ-уудын эрх зүйн орчныг боловсронгуй болгож үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлэх
3. Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах
4. “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн найруулж НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах
5. Өмчийн харилцаатай холбоотой дүрэм, журамд нэмэлт өөрчлөлтийг шинэчлэн боловсруулж НИТХ-д өргөн барьж хэлэлцүүлэх
6. “Нийслэлийн өмчийн менежментийг сайжруулах бодлогын баримт бичиг” боловсруулан батлуулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах
7. Нийслэлийн өмч хувьчлалын 2019 оны хөтөлбөр боловсруулж, шийдвэрлүүлэх
8. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд болон оролцоотой компаниудад компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх
9. Менежментийн болон удирдлагын гэрээтэй аж ахуйн нэгжүүдийн тулгамдаж буй асуудлуудыг судлан, шийдвэрлүүлэх боломжит арга хэмжээ авах
10. Нийслэлийн өмчит 21 байгууллагын 36 тээврийн хэрэгслийн чанар байдалд дүгнэлт хийсэн бөгөөд 27 тээврийн хэрэгслийг данснаас хасах асуудлыг НЗД-ын захирамжаар шийдвэрлүүлэх
11. Байгууллагын хэтийн болон өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай, дүрэм, журам, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх
12. Албан хэрэг хөтлөлт, хариутай бичгийн шийдвэрлэлтийг сайжруулах дээд газрын цохолттой албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэх, эргэж танилцуулах асуудалд онцгой анхаарч ажиллах
13. Хариугүй албан бичгийг хүлээн авсан өдөрт нь хааж хэвшүүлэх
14. Өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг багасгах